



**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН УЛСЫН БҮРТГЭЛ,
СТАТИСТИКИЙН ГАЗАР**

**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАР**

/2015 ОН/



Өлгий 2016 он



Танилцуулгыг хянан, тохиосон:

Х.Бахыт

Танилцуулгыг нэгтгэн боловсруулсан:

Н.Манаргүл

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

Е-mail: bayan-ulgii@nso.mn

Утас: 70422432 ,70422322

Интернет хаяг: [//www.bayan-ulgii.nso.mn/](http://www.bayan-ulgii.nso.mn/)

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Өлгий хот, 2016 оны 4-р сар



АГУУЛГА

I. Оршил	3
I.1 Нэр томъёоны товч тайлбар, тодорхойлолт	4
I.2 Эдийн засагт ХАА-н салбарын эзлэх байр суурь	7
II. Мал аж ахуй	
II.2.1 Малтай өрх, малчин өрх, малчдын тоо	8
II.2.2 Малчдын соёл, ахуйн үзүүлэлт	12
II.2.3 Малын тоо	14
II.2.4 Малын сүргийн бүтэц	16
II.2.5 Малын хэрэглээний зарлага	23
II.2.6 Төл бойжилт	25
II.2.7 Том малын зүй бус хорогдол	28
II.2.8 Иргадийн хувийн малын бүлэглэлт	31
II.2.9 Шинээр гаргасан, засварласан худгийн тайлан	32
II.2.10 Малжуулалтын талаар авсан арга хэмжээ	34
II.2.11 Малын бэлчээр, тэжээлийн хүрэлцээ, хангамж	34
II.2.12 Тэжээвэр амьтад	36
III. Газар тариалан	
III.1 Тариалсан талбай	38
III.2 Хураасан ургац	38
III.3 ХАА-н эдэлбэр газар	40
IV. Дүгнэлт	41



ОРШИЛ

ХАА-н салбар нь манай улс орны эдийн засгийн баталгаа болж байдаг. Хөдөө аж ахуйн салбарын үйл ажиллагаа нь бусад хүчин зүйлээс илүүтэйгээр байгаль, цаг агаараас хамааралтай бөгөөд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нь үндсэндээ хүн амын хүнсний хэрэглээ, боловсруулах үйлдвэрлэлийн болон үйлчилгээний салбарын түүхий эдийн хэрэглээг хангахад чиглэгддэг.

Дэлхийн олон улс орнуудын нэгэн адил манай улсын эдийн засгийн хөгжилд хөдөө аж ахуйн салбар нь ихээхэн чухал байр эзэлдэг салбарын нэг юм.

Энэ удаагийн танилцуулгад мал аж ахуйн, газар тариалангийн салбарын 2015 оны төлөв байдлыг нэгтгэн тусгалаа.

“Монгол Улсын Үндсэн хууль”-нд “Мал сүрэг”-ийг үндэсний баялаг мөн гэж хуульчлан зааж, мал тооллогыг улсын хэмжээнд жил бүр зохион байгуулж, үр дүнг нь макро түвшинд хийгддэг тооцоо, судалгаанд ашиглаж, салбарын талаар удирдлагын шийдвэр гаргах мэдээллийн гол эх үүсвэр болгон ашиглаж байна.

“Статистикийн тухай” Монгол Улсын хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх заалт, Монгол Улсын Засгийн газрын 2003 оны 224 дүгээр тогтоолын дагуу Үндэсний Статистикийн хороо мал, тэжээвэр амьтад, хашаа, худгийн тооллогыг 2015 оны 12 сарын 7-ноос 17-ны өдрүүдэд улсын хэмжээнд зохион байгуулж, явууллаа.

Энэхүү танилцуулгад малын 2015 оны тооллогын дүнг нэгтгэн дүгнэснээс гадна шинээр гаргасан худаг, уст цэг, малжуулалтын талаархи мэдээллийг тусган орууллаа.

Түүнчлэн уг танилцуулгад газар тариалангийн салбарын үндсэн үзүүлэлтүүд болох тариалсан талбай, хураасан ургац, га-гийн ургацын талаарх мэдээллийг жилийн дүнгээр нэгтгэн тусгасан болно.

Салбарын бүтцээр анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар 1999 он хүртэл ДНБ-ий 30-40 орчим хувийг үйлдвэрлэж, 2000 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-д эзлэх хувийн жин буурч, үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өссөөр байна.

Хөдөө аж ахуйн салбар, үүний дотор мал аж ахуйн салбарын үйлдвэрлэл нь боловсруулах аж үйлдвэрийн салбарын хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэл, нэхмэл эдлэл үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийг нийлүүлж, боловсруулах салбар болон үйлчилгээний салбарын үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, газар тариалангийн салбар нь хүн амыг аюулгүй баталгаат хүнсээр хангах үндсэн нөхцөл нь болсоор байна.

Манай аймгийн хөдөө аж ахуйн салбарын өнөөгийн байдалд дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг боловсруулах, төлөвлөхөд энэхүү танилцуулга, судалгааны материал суурь мэдээлэл нь болно гэдэгт итгэж байна.



НЭР ТОМЬЁОНЫ ТОВЧ ТАЙЛБАР, ТОДОРХОЙЛОЛТ

Малтай өрх. Малыг ахуй амьдралдаа туслах чанарын үүрэгтэй өсгөн үржүүлдэг өрх

Малчин өрх. Жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр нь болж байгаа өрх

Малчид. Жилийн 4 улирлын туршид мал аж ахуй эрхэлж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа 16 ба түүнээс дээш насны хүмүүсийг хэлнэ.

Бодод шилжүүлэх коэффициент:

1 адуу, үхэр – 1 бод
1 тэмээ - 1.5 бод
6 хонь - 1 бод
8 ямаа - 1 бод

Бодод шилжүүлэх коэффициентийг таван төрлийн малыг нэг төрлийн малд шилжүүлэн малын өсөлт, бууралтыг гаргах, үр ашгийг тооцоход ашиглана.

Бог малд буюу хонин толгойд шилжүүлэх коэффициент:

1 тэмээ - 5 хонь
1 адуу - 7 хонь
1 үхэр - 6 хонь
1 хонь - 1 хонь
1 ямаа - 0.9 хонь

Богд шилжүүлэх коэффициентийг малын тэжээлийн хүрэлцээ, хангамж, бэлчээрийн даацыг тодорхойлон гаргахад ашиглана.

Нас гүйцсэн мал. Малын төрөл бүр дээр дараах насны малыг хамруулна.

Тэмээ – 4 настай, 5 ба түүнээс дээш настай
Адуу – 3 настай, 4 ба түүнээс дээш настай
Үхэр – 2 настай, 3 ба түүнээс дээш настай
Бог мал – тухайн жилийн төл малаас бусад насны мал

Өсвөр насны мал

Тэмээ-Өмнөх оны төл, 2, 3 настай
Адуу- Өмнөх оны төл, 2 настай
Үхэр- Өмнөх оны төл

Төл мал. Тухайн жилийн төлийг хэлнэ.

Бэлэн хээлтэгч. Малын төрөл бүр дээр нас гүйцсэн эм малыг хамруулна.

Малын тоо, толгойн өсөлт. Оны эцсийн малаас оны эхний малыг хасч, малын тооны өөрчлөлтийг тоогоор илэрхийлнэ. Оны эцсийн малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлж, өсөлт, бууралтыг хувиар илэрхийлнэ. Малын өсөлтийн **орлого тал** нь төл бойжилт, **зарлага тал нь** хэрэглээний зарлага, том малын зүй бус хорогдол байна.

Төллөлтийн хувь. Төллөсөн хээлтэгчийн тоог оны эхний хээлтэгчийн тоонд харьцуулан, 100 –гаар үржүүлэн тооцно.

Бойжилтын хувь. Бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулан 100–гаар үржүүлэн тооцно.



100 эхээс бойжуулсан төл. Бойжуулсан төлийн тоог оны эхний хээлтэгч малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо. Хээлтэгч малын тоог хээлтүүлэгч малын тоонд харьцуулж, тооцно.

1 хээлтүүлэгчид ногдох хээлтэгчийн тооны норм нь:

Буур - 20-25, Азарга - 12-15, Бух - 35-45,

Хуц, ухна - 25-30

Том малын зүй бус хорогдолд өвчний (халдвартай, халдваргүй) хорогдол, гэнэтийн аюулын (цас зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг) хорогдол, бусад шалтгааны (малын хариулга, арчилгаа маллагаатай холбогдон гарсан) хорогдлыг хамруулна.

Том малын зүй бус хорогдлын оны эхний малд эзлэх хувь. Зүй бусаар хорогдсон том малын тоог оны эхний малын тоонд харьцуулан 100-гаар үржүүлэн тооцно.

Малын хэрэглээний зарлага.

Оны эхний малын тоон дээр бойжуулсан төлийг нэмж, том малын зүй бус хорогдол, оны эцсийн малын тоог хасч, тооцно.

Малын хашааны хангамж. Хашааны хангамжийг гаргахдаа хашааны багтаамжийг малын тоонд харьцуулж тооцно. Бод малын хашааны хангамжийг гаргахдаа бодын хашааны багтаамжийг үхрийн тоонд, харин бог малынхыг богийн хашааны багтаамжийг бог малын /хонь, ямааны/ тоонд харьцуулж тооцно.

Тэжээл хангамж. Тэжээлийн хангамжийг гаргахдаа тэжээлийн нэгжид шилжүүлсэн тэжээлийн хэмжээг хонин толгойд шилжүүлсэн малын тоонд харьцуулан тооцно. Малын тэжээлийн хангамж, бэлчээрийн даацыг гаргахдаа малыг хонин толгойд шилжүүлснээр тооцно.

Тэжээлийн нэгжид шилжүүлэх коэффициент. Бэлтгэсэн тэжээл нь илчлэг, чанарын байдлаараа харилцан адилгүй байдаг учраас нэг тэжээлийн нэгжид шилжүүлж тэжээлийн хангамжийг гаргана. Үүний тулд:

Хадлан өвс -0.45, Таримал тэжээл -0.35, Даршны ургамал-0.25,

Гар тэжээл, хужир шүү -1.00, Төмс ногооны хаягдал -0.22,

Үр тарианы хаягдал -0.90, Лай -0.40, Сүрэл -0.25

гэсэн итгэлцүүрүүдийг ашиглан тэжээлийн нэгжид шилжүүлнэ.

Малын тэжээлийн ангилал. Малын тэжээлийг ургамлын гаралтай, амьтны гаралтай, эрдэс тэжээлийн гаралтай гэж ангилна.

- Ургамлын гаралтай тэжээлд өвс, сүрэл, үр тариа, буурцгийн төрлийн ургамал багтах бөгөөд бүдүүн, хүчит, шүүст тэжээл гэж ангилна.
 1. Бүдүүн тэжээл- өвс, сүрэл, нэг наст ба олон наст өвс орно.
 2. Хүчит тэжээл- үр тариа, үр тарианы хаягдал, вандуй, буурцаг орно.
 3. Шүүст тэжээл - Бүх төрлийн дарш, төмс ногооны хаягдал орно.
- Амьтны гаралтай тэжээлд яс, цусны гурил зэрэг орно.
- Эрдэс тэжээлд давс, хужир шүү орно.

Тариалангийн талбай . Хөдөө аж ахуйн таримал ургамлыг тариалсан талбайг


хэлнэ. Тариалангийн талбайг тариалсан талбай, хураасан талбай, өнжсөн талбай, уринш боловсруулсан талбай гэж ангилна.

**ЭДИЙН ЗАСАГТ ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ**

2015 оны эцэст тоолуулсан малын тоо 7.3 хувиар өсөж хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртөг урьдчилсан тооцоогоор 7.3 хувь буюу 136.9 тэрбум төгрөг болж өслөө. Өнгөрсөн жилийн цаг агаарын байдлаас шалтгаалж малын тоо өсөж, мал аж ахуйн голлох үйлдвэрлэл болох бойжуулсан төлийн өссөн нь хөдөө аж ахуйн салбарын нэмэгдэл өртгийн энэхүү өсөлтөнд голлон нөлөөлсөн байна.

АЙМГИЙН ДНБ БОЛОН ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ, ЭЗЛЭХ ХУВЬ

	2011	2012	2013	2014	2015	/тэрбум.төг/	
						2015/2014 %	Зөрүү
Бүгд	143.2	179.6	225.5	283.0	340.5	120.3	57.5
ХАА-н салбар	53.4	66.9	92.9	127.6	136.9	107.3	9.3
ДНБ-д эзлэх хувь	37.3	37.2	41.2	45.1	40.2	89.2	-4.9

ХАА-Н САЛБАРЫН НЭМЭГДЭЛ ӨРТӨГ /тэрбум.төг/


Салбарын бүтцээс үзвэл анхдагч салбар буюу хөдөө аж ахуйн салбар, үүн дотроо мал аж ахуйн салбар аймгийн ДНБ-ий 60-70 орчим хувийг үйлдвэрлэж, 2006 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт учирсан байгалийн гамшиг, жижиг дунд үйлдвэр, үйлчилгээний салбарын өсөлтөөс шалтгаалж, хөдөө аж ахуйн салбарын ДНБ-нд эзлэх хувийн жин буурч, үүний оронд үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын хувийн жин өсөж байна.

Улсын хэмжээнд ХАА-н салбарын ДНБ-д эзлэх хувь буурах хандлагатай байна. ХАА-н салбар нь 2001 онд ДНБ-ний 24.9 хувийг эзэлж байсан бол 2015 онд 15 хувийг эзэлж байна. Баруун бүсийн дүнд эзлэх хувь 2001-2007 онд өсөж 74.2-т хүрч 2015 онд 53.5 хувь болон бууржээ. Баян-Өлгий аймгийн хувьд хандлага нь



баруун бүсийнхтэй ойролцоо байгаа бөгөөд 2004 онд 67.2 хувьд хүрч , 2015 онд 40.2 хувь болж буурлаа.

ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРЫН ДНБ-Д ЭЗЛЭХ ХУВЬ



2015 ОНЫ МАЛ ТООЛЛОГЫН ДҮН

Малтай өрх малчдын тоо, тэдний соёл ахуйн үзүүлэлтүүд

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ, МАЛЧДЫН ТОО, /сумаар/

/ 2015 он /

Сумын нэр	Малтай өрхийн тоо	Малчин өрхийн тоо	15-с дээш насны малчдын тоо	Үүнээс			Нийт малчдаас эмэгтэй
				15-34 настай	35-59 настай	60 -с дээш	
Алтай	1 007	725	1 354	485	732	137	627
Алтанцөгц	669	364	741	252	428	61	330
Баяннуур	978	538	1 051	351	631	69	468
Бугат	730	441	848	327	433	88	394
Булган	1 089	735	1 433	598	761	74	622
Буянт	639	453	881	277	525	79	412
Дэлүүн	1 317	928	1 917	780	1 030	107	876
Ногооннуур	1 469	786	1 664	805	743	116	779
Сагсай	1 085	616	1 284	503	624	157	613
Толбо	865	622	1 231	446	659	126	568
Улаанхус	1 568	1 216	2 679	1 056	1 402	221	1 212
Цэнгэл	1 721	1 446	3 311	1 515	1 462	334	1 568
Өлгий	1 471	2	4	1	3	0	2
Дүн	14608	8872	18398	7396	9433	1569	8471




Аймгийн хэмжээгээр 2015 онд мал тооллогын дүнгээр мал бүхий 14608 өрх тоологдсон байна. Үүний 60.7 хувь буюу 8872 өрх нь жилийн 4 улирлын туршид малаа маллаж, малын ашиг шим нь тэдний амьжиргааны эх үүсвэр болж байгаа малчин өрх, 39.3 хувь буюу 5736 өрх нь малыг амьдрал ахуйдаа туслах чанартайгаар өсгөн үржүүлж буй өрх байна.

2015 онд дүнгээр 18398 малчид мал аж ахуйн үйлдвэрлэлд ажиллаж байгаа бөгөөд малчдыг насны бүлгээр авч үзвэл 40.2 хувь нь 15-34 настай, 51.3 хувь нь 35-59 насны, 8.5 хувь нь тэтгэврийн насны хүмүүс байна. Сүүлийн жилүүдэд малчдын дотор 15-34 насны залуу малчдын эзлэх хувийн жин буурч, 35-аас дээш насных болон тэтгэврийн насны малчдын эзлэх хувийн жин өсөж 2015 онд 35-55 насны малчдын тоо 3.5 хувь буюу 316 хүнээр, 55-с дээш насны буюу тэтгэврийн насны малчдын тоо 5.2 хувь буюу 77 хүнээр нэмэгджээ.

2015 онд малчин өрхийн тоо 2014 онтой харьцуулахад 0.5 хувь буюу 49 өрхөөр буурлаа.


Малчин өрхийн тоо Баяннуур, Алтай, Булган сумаас бусад бүх сумдад буурч, малтай өрхийн тоо Алтанцөгц, Баяннуур, Булган, Буянт, Ногооннуур, Сагсай, Толбо сумаас бусад сумуудад мөн буурсан байна. Малтай өрхийн тоо сүүлийн 4 жилийн үзүүлэлтээс харахад өмнөх жилүүдэд өссөн бол 2014-2015 онд бага зэрэг буурсан байгаа нь харагдана.

МАЛТАЙ ӨРХ, МАЛЧИН ӨРХ /мян.өрх/



**МАЛТАЙ ӨРХ БОЛОН МАЛЧИН ӨРХИЙН ТОО /сумаар/**


Сумын нэр	Малтай өрхийн тоо				Малчин өрхийн тоо			
	2012	2013	2014	2015	2012	2013	2014	2015
Алтай	994	989	1 014	1 007	721	650	720	725
Алтанцөгц	627	635	658	669	329	343	382	364
Баяннуур	937	917	955	978	498	427	451	538
Бугат	690	754	734	730	409	453	466	441
Булган	1055	1091	1 086	1 089	674	721	729	735
Буянт	550	597	630	639	413	426	465	453
Дэлүүн	1283	1306	1 342	1 317	800	918	940	928
Ногооннуур	1359	1399	1 454	1 469	775	648	765	786
Сагсай	1002	1044	1 067	1 085	616	624	643	616
Толбо	797	821	850	865	575	580	629	622
Улаанхус	1549	1542	1 579	1 568	1192	1230	1 249	1 216
Цэнгэл	1590	1629	1 741	1 721	1339	1370	1 478	1 446
Өлгий	1087	1380	1 526	1 471	42	2	4	2
Дүн	13520	14104	14636	14608	8383	8392	8921	8872

МАЛЧДЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР, 2015 ОН

**МАЛЧДЫН НИЙГМИЙН АСУУДАЛ, ОЛОН ЖИЛЭЭР**

	2001	2002	2003	2004	2005	2006	2007	2008
Малтай өрх	15920	15761	16298	16416	15499	15194	15126	14998
Малчин өрх	11122	11223	11200	11511	10961	11078	11102	9723
Малчдын тоо	23596	24207	23513	24889	23234	23071	23682	22886
Үүнээс: 15-34 насны	14250	14095	13805	14196	13428	13241	13114	12377
35-59 насны	7779	8443	8035	8402	8096	8548	9140	8795
Тэтгэврийн насны	1567	1669	1673	2291	1710	1282	1428	1714

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2015/ 2014%
Малтай өрх	14930	13862	13858	13520	14104	14636	14608	99.8
Малчин өрх	10380	9436	9334	8383	8392	8921	8872	99.5
Малчдын тоо	21141	18685	18895	17808	17723	18302	18398	100.5
Үүнээс: 15-34 насны	10589	9528	9037	8644	8120	7693	7396	96.1
35-59 насны	8189	7195	7853	7902	8249	9117	9433	103.5
Тэтгэврийн насны	2363	1962	2005	1262	1354	1492	1569	105.2

МАЛЧДЫН ТОО, /мянга/


1971 1980 1990 1995 2000 2005 2010 2012 2013 2014 2015

**Малчдын соёл, ахуйн үзүүлэлт****МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХИЙН ТООГООР, ЖИЛЭЭР**

	2007	2008	2009	2010	2011	2012	2013	2014	2015
Цахилгаантай өрх	6250	8841	9194	9038	8947	8362	6635	7595	7289
Телевизортой	5412	7964	8935	8409	8407	8300	4745	4453	4355
Автомашинтай	2232	2604	2862	2780	2663	2693	2680	2997	3542
Мотоциклтэй	2348	2530	2437	2697	3585	3594	3187	3245	3475
Худагтай	1158	1574	1902	1198	1215	1215	2116	3029	2974

2015 оны тооллогоор нийт малчин өрхийн 82.1 хувь нь цахилгааны эх үүсгүүртэй, 49 хувь нь телевизортой, 40 хувь нь авто машинтай, 39.2 хувь нь мотоциклтэй, 33.5 хувь нь худагтай гэсэн дүн гарлаа.

Сүүлийн жилүүдэд малчин өрхийн цахилгаан эрчим хүчний хэрэглээг нарны зайн эрчим хүчээр хангах арга хэмжээг авч явуулсны үр дүнд цахилгаан үүсгүүртэй өрхийн тоо жилээс жилд нэмэгдсээр байна. 2007 онд 6.2 мянган өрх цахилгааны эх үүсгүүртэй байсан бол 2009 онд 9.2 мянга болж 1.5 дахин буюу 2.9 мянган өрхөөр нэмэгдсэн байна. Харин 2013 онд энэ үзүүлэлт 6.6 мянга болж 27.8 хувиар багассан нь сүүлийн жилүүдэд төврүү шилжих хөдөлгөөн ихэссэнтэй холбоотой малчин өрхийн тоо багасч улмаар цахилгааны эх үүсгүүртэй өрхийн тоо буурч байсан бол сүүлийн жилүүдэд засгийн газраас малчин өрхөд ноосны урамшуулал олгох бодлого хэрэгжүүлж байгаатай холбоотой 2015 онд малчин өрхийн тоо нэмэгдэж үүнийг дагаад цахилгаантай өрхийн тоо нэмэгдсэн байна. 2015 онд авто машинтай өрхийн тоо 545 өрхөөр, мотоциклтэй өрхийн тоо 230 өрхөөр нэмэгдэж, худагтай өрхийн тоо 55 өрхөөр, телевизортой өрхийн тоо 98 өрхөөр буурлаа. Нийт цахилгаан үүсгүүртэй өрхийн 94,8 хувь нь нарны, 0.1 хувийг салхины, үлдсэн 5.1 хувийг цахилгааны төвлөрсөн системд холбогдсон өрх эзэлж байна.

МАЛЧДЫН АХУЙ СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ, ӨРХӨӨР /мян.өрх/



МАЛЧДЫН АХУЙ, СОЁЛЫН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТ

/өрхийн тоогоор, 2015/

Сумын нэр	Баг хорооны тоо	Цахилгааны эх үүсгэвэртэй өрх	Үүнээс		Радиотой өрх	Оёдлын машинтай өрх	Телевизортэй өрх	Малын хашаатай өрх
			Нарны	Салхины				
Алтай	5	583	568	1	318	436	412	868
Алтанцөгц	4	331	326		283	286	243	507
Баяннуур	5	474	352	2	387	402	362	861
Бугат	4	386	385		317	298	200	564
Булган	7	665	657	1	264	477	518	678
Буянт	4	389	383		335	348	353	426
Дэлүүн	10	869	869		538	419	382	944
Ногооннуур	9	459	434		217	203	158	1354
Сагсай	6	474	473	1	394	371	264	988
Толбо	6	506	477	1	376	383	370	667
Улаанхус	8	888	871	2	632	619	420	1297
Цэнгэл	9	1263	1115		853	782	672	1471
Өлгий	13	2	1		1	1	1	1495
Дүн	90	7289	6911	8	4915	5025	4355	12120

Сумын нэр	Худагтай өрх	Авто машинтай		Мотоциклтэй		Гар утастай		Хийсэн эсгий (м)
		Өрхийн тоо	Машины тоо	Өрхийн тоо	Мотоцикл-ийн тоо	Өрхийн тоо	Гар утасны тоо	
Алтай	151	224	225	374	375	482	532	1149
Алтанцөгц	151	198	199	231	232	317	464	180
Баяннуур	591	283	286	351	353	433	495	1438
Бугат	70	228	235	144	144	274	276	607
Булган	189	243	245	352	356	439	443	506
Буянт	6	221	222	361	364	352	369	92
Дэлүүн	34	461	477	377	377	447	457	1336
Ногооннуур	730	274	281	250	250	310	311	36
Сагсай	653	288	192	194	194	399	408	1707
Толбо	26	333	335	277	278	495	507	1116
Улаанхус	222	341	344	453	456	584	588	1376
Цэнгэл	135	448	449	111	111	614	722	831
Өлгий	16	0	0	0	0	1	1	0
Дүн	2974	3542	3490	3475	3490	5147	5573	10374

**МАЛ, ТЭЖЭЭВЭР АМЬТДЫН ТОО, СҮРГИЙН БҮТЭЦ**

Малын тоо. 2015 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр малын тоо 2021.0 мянган толгойд хүрч, өмнөх оныхоос 7.3 хувь буюу 137436 толгойгоор өслөө. Үүнд тэмээ 46 толгойгоор, адуу 7729 толгой, үхэр 17318 толгой, хонь 50759 толгой, ямаа 61584 толгойгоор тус тус нэмэгдлээ. Өнгөрсөн онтой харьцуулахад 2015 онд бүх сумдад малын тоо 4.2-14.9 хувь буюу 7539-25625 толгойгоор өссөн байна.

2015 онд нийт 60.5 мянган сарлаг тоологдсон нь нийт үхэр сүргийн 41.8 хувийг эзэлж байна.

МАЛЫН ТОО, ТӨРЛӨӨР


	2011	2012	2013	2014	2015	/толгойн тоогоор/	
						2015/2014	
						%	зөрүү
Бодоор /мян.тол/	302.6	326.5	377.2	446.3	487.6	109.3	41.3
Толгойн тоо	1302786	1410503	1604080	1883610	2021046	107.3	137436
Тэмээ	3992.0	4192.0	4348.0	4671	4717	101.0	46
Адуу	48532	51705	58440	69562	77291	111.1	7729
Үхэр	80815	87198	105079	127443	144761	113.6	17318
Хонь	506911	574376	662827	799861	850620	106.3	50759
Ямаа	662536	693032	773386	882073	943657	107.0	61584

МАЛЫН ТОО, СУМААР

	2011	2012	2013	2014	2015	2015/2014	
						%	зөрүү
Алтай	110788	122834	125427	145454	154 484	106.2	9030
Алтанцөгц	51472	59338	72052	87619	95 219	108.7	7600
Баяннуур	97183	108243	116784	143819	151 434	105.3	7615
Бугат	60706	61714	75770	86670	94 209	108.7	7539
Булган	75666	81075	90810	105078	120 785	114.9	15707
Буянт	74208	87501	104146	120243	130 226	108.3	9983
Дэлүүн	166481	180361	207784	236491	262 116	110.8	25625
Ногооннуур	123145	124189	146023	173671	183 847	105.9	10176
Сагсай	90859	102663	112657	130645	146 003	111.8	15358
Толбо	104146	119052	134027	159064	167 408	105.2	8344
Улаанхус	135770	144615	158402	186770	196 223	105.1	9453
Цэнгэл	195119	199362	236422	281880	293 785	104.2	11905
Өлгий	17243	19556	23776	26206	25 307	96.6	-899
Дүн	1302786	1410503	1604080	1883610	2021046	107.3	137436



МАЛЫН ТОО



2015 онд улсын хэмжээнд нийт 55957.6 мянган толгой мал тоологдсоны 3.6 хувийг манай аймаг эзэлж байна. Үүнээс, тэмээ 1.3 хувь, адуу 2.3 хувь, үхэр 3.8 хувь, хонь 3.4 хувь, ямаа 4.0 хувийг тус тус эзэлнэ.

МАЛЫН ТОО, УЛСЫН ДҮНД ЭЗЛЭХ ХУВЬ

	/мян.тол/								
	Малын тоо /Аймгийн дүнгээр/			Малын тоо /Улсын дүнгээр/			Улсын дүнд эзлэх %		
	2013	2014	2015	2013	2014	2015	2013	2014	2015
Бодоор	377.2	446.3	487.6	11685.4	13553.8	14729.3	3.2	3.3	3.3
Толгойн тоо	1604.0	1883.6	2021.0	45144.4	51982.7	55957.6	3.6	3.6	3.6
Тэмээ	4.3	4.7	4.7	321.5	349.3	367.9	1.3	1.3	1.3
Адуу	58.4	69.6	77.3	2619.4	2995.8	3294.6	2.2	2.3	2.3
Үхэр	105.1	127.4	144.8	2909.5	3413.9	3779.5	3.6	3.7	3.8
Хонь	662.8	799.8	850.6	20066.4	23214.8	24933.4	3.3	3.4	3.4
Ямаа	773.4	882.1	943.6	19227.6	22008.9	23582.2	4.0	4.0	4.0

ИРГЭДИЙН ХУВИЙН МАЛЫН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ

	1990	1995	2000	2009	2010	2011	2012
Малтай өрхийн тоо	13465	14456	15402	14930	13862	13858	13858
Бодоор	220439	365950	340924	293285	253951	293760	293760
Толгойн тоо	607645	1255345	1299891	1296751	1122835	1298851	1298851
Тэмээ	5012	8445	6943	3863	3764	3989	3989
Адуу	58812	78561	67905	50453	43077	48160	48160
Үхэр	84156	118199	95975	70671	66019	80785	80785
Хонь	299884	606131	611910	521362	457245	504472	504472
Ямаа	159781	444009	517158	650402	552730	661445	661445




	2013	2014	2015	2015/1990		2015/2014	
				%	Өсөлт(-,+)	%	Өсөлт(-,+)
Малтай өрхийн тоо	14104	14636	14608	108.5	1143	99.8	-28
Бодоор	376132	446352	487618	221.2	267179	109.2	41266
Толгойн тоо	1600067	1878450	2016300	331.8	1408655	107.3	137850
Тэмээ	4346	4669	4716	94.1	-296	101.0	47
Адуу	57976	68863	76593	130.2	17781	111.2	7730
Үхэр	105023	127306	144650	171.9	60494	113.6	17344
Хонь	660576	796869	847952	282.8	548068	106.4	51083
Ямаа	772146	880743	942389	589.8	782608	107.0	61646

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР

	2010	2011	2012	2013	2014	2015
Тэмээ	0.3	0.3	0.3	0.3	0.2	0.2
Адуу	3.9	3.7	3.7	3.6	3.7	3.8
Үхэр	5.9	6.2	6.2	6.6	6.8	7.2
Хонь	40.8	38.9	40.7	41.3	42.5	42.1
Ямаа	49.1	50.9	49.1	48.2	46.8	46.7
Бүгд	100.0	100.0	100.0	100.0	100.0	100.0

2015 оны малын тоо толгойн өсөлт нь үндсэндээ бог малын өсөлтөөр хангагдсан бөгөөд нийт өсөлтийн 46.7 хувийг ямаа, 42.1 хувийг хонь, 7.2 хувийг үхэр, 3.8 хувийг адуу, 0.2 хувийг тэмээний өсөлт хангасан байна.

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, ХУВИАР






Нийт сүргийн 1979 онд 27.6 хувийг ямаа, 58.5 хувийг хонь, 7.1 хувийг үхэр, 5.7 хувийг адуу, 1.1 хувийг тэмээ эзэлж байсан бол 2015 онд 46.7 хувийг ямаа, 42.1 хувийг хонь, 7.2 хувийг үхэр, 3.8 хувийг адуу, 0.2 хувийг тэмээ эзэлж байна.

Сүргийн бүтцэд 1971-2015 онд ямааны эзлэх хувь 19.1 пунктээр, үхэр 0.1 пунктээр өсч, харин хонины эзлэх хувь 16.4 пункт, адууных 1.9 пункт, тэмээ 0.9 пунктээр буурсан байна.

Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх хонины тоо толгойн хэмжээ буурах хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт мал сүргийн 1991 онд 60.7 хувийг хонь эзэлж байсан бол 1992 оноос буурч 2015 онд 42.1 хувьд хүрчээ. Аймгийн хонины тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь 2001-2015 онд улсын болон баруун бүсийн дүнгээс доогуур түвшинд байна.

ХОНИНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ




Улсын хэмжээнд нийт сүрэгт эзлэх ямааны тоо толгойн хэмжээ 1971-1992 онд тогтвортой байсан бол 1992 оноос огцом өсөх хандлагатай байна. Баян-Өлгий аймгийн нийт сүргийн 1971 онд 26.3 хувийг ямаа эзэлж байсан бол 2015 онд 46.7 хувьд хүрчээ. Ямааны тоо толгойн нийт сүрэгт эзлэх хувь улсын дүнгээс 4.6 пунктээр өндөр байгаа ч баруун бүсийн дүнгээс 1.8 пунктээр бага байна.

Аймгийн малын тооны олон жилийн динамикийг харахад түүний өөрчлөлтөд нийгмийн өөрчлөлтөөс гадна цаг агаарын хүчин зүйл хүчтэй нөлөөлж байна. 1990-ээд оны эхээр мал хувьчилсны дараа малын тооны тодорхой өсөлт гарсан боловч 2001, 2002, 2010 оны өвөл, хаврын зуд малын тоог ихээхэн бууруулсан билээ. Энэ хандлага бүх төрлийн малд ажиглагдсан бөгөөд зудны дараа түргэн өсөлттэй ямаа, хонь хурдан өссөн байна. Ноолуурын үнийн өсөлтөөс шалтгаалан ямаагаа түлхүү өсгөх хандлагатай байна.



ЯМААНЫ ТОО ТОЛГОЙН НИЙТ СҮРЭГТ ЭЗЛЭХ ХУВЬ



ХЭЭЛТЭГЧ МАЛЫН ТОО

	1990	1995	2000	2004	2005	2006	2007	2008
Дүн	610244	523087	596729	584869	585170	637726	681498	664758
Ингэ	2749	1037	2102	1430	1061	1074	1075	1034
Гүү	21685	17859	23145	18455	17213	18356	18909	17335
Үнээ	45051	37530	46458	37417	34016	36785	38853	34579
Эм хонь	398136	291993	291630	252584	251504	271093	283481	269837
Эм ямаа	142623	174668	233394	274983	281376	310418	339180	341973

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	2015/2014 %
Дүн	602941	519337	566233	626572	685412	797053	835766	104.9
Ингэ	1019	1084	1181	1279	1333	1453	1384	95.3
Гүү	16172	13788	14716	15573	17305	20594	22770	110.6
Үнээ	31193	30544	34998	38083	43803	51023	55884	109.5
Эм хонь	243500	213163	226635	260038	291846	349634	364523	104.3
Эх ямаа	311057	260758	288703	311599	331125	374349	391205	104.5

Хээлтэгч мал нь нийт малын 41.3 хувийг эзэлж байгаа бөгөөд тэмээн сүргийн 29.3 хувь, адуун сүргийн 29.5 хувь, үхэр сүргийн 38.6 хувь, хонин сүргийн 42.9 хувь, ямаан сүргийн 41.5 хувийг тус тус эзэлж байна.



Мал аж ахуйн эрдэмтэн судлаачдын үзэж байгаагаар мал аж ахуйн нөхөн үйлдвэрлэлийг хэвийн хэмжээнд байлгахад хээлтэгч мал бод малын хувьд сүргийн 50 – 55 хувь, бог малын хувьд сүргийн 60 – 65 хувийг эзэлж байвал зохимжтой байна гэж үздэг бөгөөд сүүлийн жилүүдэд энэ харьцаа алдагдаж, сүүлийн 5 жилийн байдлаар хээлтэгч малын эзлэх хувь бод малд дунджаар 35.3 хувь, бог малд 42,1 хувь байна.

НИЙТ МАЛЫН ТООНД ХЭЭЛТЭГЧИЙН ЭЗЛЭХ ХУВЬ

	2011	2012	2013	2014	2015	2015/2014	
						%	Зөрүү
Дүн	48.1	48.6	42.7	44.4	41.4	93.2	-3.0
Ингэ	32.0	31.8	30.7	29.6	29.3	99.0	-0.3
Гүү	32.1	33.5	29.6	32.7	29.5	90.0	-3.3
Үнээ	47.1	50.2	41.7	43.9	38.6	88.0	-5.2
Эм хонь	51.3	50.8	44.0	45.6	42.9	94.0	-2.7
Эх ямаа	47.0	47.8	42.8	44.4	41.5	93.5	-2.9

ТӨЛ ӨГӨӨГҮЙ ХЭЭЛТЭГЧ

Сумын нэр	2014	2015	Үүнээс					Оны эхний хээлтэгчид эзлэх %	Өмнөх оноос зөрүү /-,+ /
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа		
Алтай	655	495		101	102	121	171	0.8	-160
Алтанцөгц	801	905		76	153	194	482	2.4	104
Баяннуур	3218	590		90	203	75	222	1.0	-2628
Бугат	646	973		58	128	277	510	2.6	327
Булган	3568	1991	8	130	310	658	885	4.5	-1577
Буянт	299	1080	1	81	120	368	510	2.1	781
Дэлүүн	1082	3593	20	189	309	1196	1879	3.6	2511
Ногооннуур	595	2246	5	34	116	1017	1074	3.2	1651
Сагсай	328	225		36	59	97	33	0.4	-103
Толбо	610	146		9	18	80	39	0.2	-464
Улаанхус	926	1048		69	150	390	439	1.3	122
Цэнгэл	1166	632		36	61	231	304	0.5	-534
Өлгий	1895	749	2	70	229	134	314	6.1	-1146
Дүн	15789	14673	36	979	1958	4838	6862	1.8	-1116

**ХЭЭЛ ХАЯСАН ХЭЭЛТЭГЧ**

	1990	1995	2000	2004	2005	2006	2007	2008
Дүн	20649	5287	52085	16609	70210	15000	35586	105416
Ингэ	47	23	15	47	26	4	20	9
Гүү	2269	703	5569	1972	3428	1294	2046	5459
Үнээ	1701	822	5859	2207	4242	1263	2472	6499
Эм хонь	9158	1891	11785	3913	11122	4134	9041	17446
Эм ямаа	7474	1848	28857	8470	51392	8305	22007	76003

	2009	2010	2011	2012	2013	2014	2015	<u>2015/2014</u> %
Дүн	90454	105922	7876	59246	13636	6061	4369	72.1
Ингэ	24	40	3	2	6	7	2	28.6
Гүү	3046	3669	557	362	290	217	162	74.7
Үнээ	2282	2514	428	5126	505	245	238	97.1
Эм хонь	8463	11392	1047	7046	2876	1193	1384	116.0
Эм ямаа	76639	88307	5841	46710	9959	4399	2583	58.7

2015 онд оны эхний төллөх насны хээлтэгчийн 0.5 хувь буюу 4369 толгой мал хээл хаясаны улмаас төл өгөөгүй байна. Хээл хаясан малын тоо 2014 оныхоос 1692 толгойгоор буюу 27.9 хувь буурлаа.

Төл өгөөгүй нийт хээлтэгчийн 29.8 хувь буюу 4369 нь хээл хаясан хээлтэгч, 70.2 хувь буюу 10304 нь сувайрсан хээлтэгч байна.

Сувайрсан малын тоо 2014 оныхоос 5.9 хувь буюу 576 толгойгоор нэмэгдэв.


СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ

	1990	1995	2000	2004	2005	2006	2007	2008
Дүн	19699	7807	22376	15463	26113	13943	13943	24603
Ингэ	1444	41	220	25	19	17	17	17
Гүү	5058	1203	3421	2805	2138	1480	1480	1908
Үнээ	6085	1777	4742	3175	3698	2429	2429	4036
Эм хонь	4384	3014	6896	4434	9425	4155	4155	7317
Эм ямаа	2728	1772	7097	5024	10833	5862	5862	11325



	2009	2010	2011	2012	2013	2014	2015	<u>2015/2014</u> %
Дүн	30953	48167	11876	19683	15932	9728	10304	105.9
Ингэ	3	16	14	17	39	44	34	77.3
Гүү	2086	2493	1181	1990	1392	945	817	86.5
Үнээ	3820	4568	2234	2424	2629	1739	1720	98.9
Эм хонь	9097	20293	4027	6644	4996	2763	3454	125.0
Эм ямаа	15947	20797	4420	8608	6876	4237	4279	101.0

ХЭЭЛ ХАЯСАН, СУВАЙРСАН ХЭЭЛТЭГЧ /мян.тол/



ХЭЭЛТҮҮЛЭГЧ МАЛЫН ТОО

	1995	2000	2012	2013	2014	2015	<u>2015</u> <u>2014%</u>
Буур	96	67	105	86	75	77	102.7
Азарга	2617	2429	1566	1677	1876	2233	119.0
Бух	3651	2134	1923	2192	2298	2874	125.1
Хуц	7721	6784	6017	6610	7243	7695	106.2
Ухна	5716	5986	7320	7566	8143	8386	103.0
Дүн	19801	17400	16931	18131	19635	21265	108.3

2015 онд 21265 толгой хээлтүүлэгч мал тоологдож 2014 оныхоос 8.3 хувь буюу 1630 толгойгоор нэмэгдэв.



НЭГ ХЭЭЛТҮҮЛЭГЧИД НООГДОХ ХЭЭЛТЭГЧИЙН ТОО

	үржлийн норм	2011	2012	2013	2014	2015	<u>2015</u> 2014 %
Ингэ	20-25	16	12	16	19	18	94.6
Гүү	12-15	10	10	10	11	10	92.7
Үнээ	35-45	18	20	20	22	19	88.4
Эм хонь	25-30	41	43	44	48	47	98.7
Эм ямаа	25-30	40	43	44	46	47	101.4

Хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироо нь бод малын хувьд үржлийн нормоор, харин бог малын хувьд алдагдсан хэвээр байна. Үржлийн нормоор бог малын нэг хээлтүүлэгчид 25-30 хээлтэгч ногдох ёстой атал 47 эм хонь, эм ямаа ногдож 56.6 хувиар өндөр үзүүлэлт гарч байна.

СҮРГИЙН БҮТЭЦ

	Мянган толгойгоор			Хувиар			Толгой
	2013	2014	2015	2013	2014	2015	Зөрүү
Бүгд	1604.1	1883.6	2021.0	100.0	100.0	100.0	137.4
Өсвөр насны Ажлын ба бэлтгэл насны	607.3	664.4	781.0	37.9	35.3	38.6	116.6
Хээлтэгч	293.3	402.5	383.1	18.3	21.4	18.9	-19.4
Хээлтүүлэгч	685.4	797.1	835.7	42.7	42.3	41.4	38.6
	18.1	19.6	21.2	1.1	1.0	1.1	1.6

МАЛЫН СҮРГИЙН БҮТЭЦ, 2014 ОН, СУМААР


Сумын нэр	Бүгд хувиар	Өсвөр насны төл	Ажлын ба бэлтгэл насны	Хээлтэгч	хээлтүүлэгч
Алтай	100.0	41.0	13.3	44.4	1.3
Алтанцөгц	100.0	38.4	17.3	43.5	0.8
Баяннуур	100.0	36.8	24.1	38.0	1.1
Бугат	100.0	39.3	17.0	42.7	1.0
Булган	100.0	35.7	21.6	41.6	1.1
Буянт	100.0	39.9	17.0	42.0	1.1
Дэлүүн	100.0	37.2	21.1	40.7	1.0
Ногооннуур	100.0	38.4	21.7	39.0	0.9
Сагсай	100.0	39.2	16.0	43.6	1.2
Толбо	100.0	37.5	23.2	38.3	1.1
Улаанхус	100.0	40.9	15.7	42.4	0.9
Цэнгэл	100.0	38.5	19.0	41.4	1.1
Өлгий	100.0	48.1	4.4	47.3	0.2
Дүн	100.0	38.6	18.9	41.4	1.1



2015 оны байдлаар нийт малын 38.6 хувь буюу 781 мянган толгой нь төл өсвөр насны мал, 18.9 хувь буюу 383.1 мянган толгой нь нас гүйцсэн ажлын ба бэлтгэл насны мал, 41.4 хувь буюу 835.7 мянган толгой нь хээлтэгч мал, 1.1 хувь буюу 21.2 мянган толгой нь хээлтүүлэгч мал байна. 2015 онд нийт малын тоонд төл өсвөр насны малын эзлэх хувийн жин өмнөх оныхоос 3.3 пунктээр, хээлтүүлэгчийн хувийн жин 0.1 пунктээр нэмэгдэж, хээлтэгчийн эзлэх хувийн жин 0.9 пунктээр, ажлын ба бэлтгэл насны малын эзлэх хувийн жин 2,5 пунктээр буурсан байна.

Малын хэрэглээний зарлага

МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГЫН БҮТЭЦ /хувиар/



2015 онд оны эхний малын 18.2 хувьтай тэнцэх 367784 толгой малыг хэрэглээнд зарцуулсан байна. 2014 оныхоос 80.3 мянган толгой буюу 27.9 хувиар нэмэгдсэн байна. Малтай нэг өрх дундажаар 25 толгой малыг хэрэглээнд зориулан зарцуулсан бол аймгийн хэмжээний нийт өрхөд харьцуулбал нэг өрх дундажаар 16 толгой малыг хэрэглээндээ зарцуулсан байна.

Хэрэглээндээ зарцуулсан нийт малын 0.1 хувийг тэмээ, 2.1 хувийг адуу, 5.2 хувийг үхэр, 46.5 хувийг хонь, 46 хувийг ямаа эзэлнэ.

Хэрэглээнд зарцуулсан малын 92.5 хувийг бог мал, 7.5 хувийг бод мал эзэлнэ. Сумаар авч үзвэл хэрэглээндээ хамгийн их мал зарцуулсан Цэнгэл сум 59.8 мянган толгой, Улаанхус 46.2 мянган толгой, Дэлүүн 33.9, Ногооннуур 33.7 мянган толгойг тус тус зарцуулсан байна.



МАЛЫН ХЭРЭГЛЭЭНИЙ ЗАРЛАГА

Сумын нэр	2014	2015	Үүнээс:				
			Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа
Алтай	22366	26589	41	876	1513	14978	9181
Алтанцөгц	13225	18807	47	350	847	6957	10606
Баяннуур	16513	27842	40	583	1040	10009	16170
Бугат	14006	18541	2	450	1002	7620	9467
Булган	17064	18271	44	388	1315	6355	10169
Буянт	17273	23698	11	374	1188	14223	7902
Дэлүүн	31073	33998	23	961	1659	15500	15855
Ногооннуур	30309	33772	42	672	1352	13444	18262
Сагсай	16887	17549	8	479	942	9224	6896
Толбо	25988	36713	10	556	1503	19499	15145
Улаанхус	34837	46257	110	985	2926	24189	18047
Цэнгэл	44907	59799	64	1113	2908	27198	28516
Өлгий	2956	5948	1	88	949	1956	2954
Дүн	287404	367784	443	7875	19144	171152	169170


Сумын нэр	Оны эхний малд эзлэх хувь						2015- 2014 зөрүү
	Бүгд	Тэмээ	Адуу	Үхэр	Хонь	Ямаа	
Алтай	18.3	11.0	11.8	11.1	20.6	17.8	4223
Алтанцөгц	21.5	8.5	11.2	18.5	23.8	21.2	5582
Баяннуур	19.4	8.3	12.2	17.0	23.1	18.2	11329
Бугат	21.4	6.5	15.0	18.8	21.5	22.1	4535
Булган	17.4	7.4	7.8	14.1	23.5	16.1	1207
Буянт	19.7	6.4	10.1	14.0	20.3	20.9	6425
Дэлүүн	14.4	8.5	9.8	9.5	16.6	13.7	2925
Ногооннуур	19.4	10.8	11.1	15.1	23.0	18.3	3463
Сагсай	13.4	2.7	8.5	10.9	14.7	12.9	662
Толбо	23.1	11.1	12.6	17.0	22.5	25.7	10725
Улаанхус	24.8	15.4	15.1	20.7	26.7	24.2	11420
Цэнгэл	21.2	9.5	11.8	17.9	22.0	21.6	14892
Өлгий	22.7	3.0	11.8	16.7	30.0	22.4	2992
Дүн	19.5	9.5	11.3	15.0	21.4	19.2	80380




Төл бойжилт

2015 оны байдлаар оны эхний төллөх насны хээлтэгчийн 99.4 хувь буюу 792571 толгой эх мал төллөж гарсан төлийн 98.5 хувь буюу 781029 төл бойжуулав. Бойжсон төлийн тоо 2014 оныхоос 116645толгой буюу 17.6 хувиар нэмэгдлээ.

БОЙЖУУЛСАН ТӨЛ, СУМААР, 2015 ОН /мян.тол/



БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР /мян.тол/



**БОЙЖУУЛСАН ТӨЛ, ОЛОН ЖИЛЭЭР**

Он	Бүгд	Ботго	Унага	Тугал	Хурга	Ишиг
1990	517616	1050	12040	33989	350970	119567
1995	497763	771	15210	33553	281715	166514
1997	532687	862	16167	38279	288883	188496
1998	390894	638	9988	29507	217656	133105
1999	528661	818	14510	36919	281421	194993
2000	432093	619	10377	30271	232228	158598
2001	464662	624	12163	28100	238312	185463
2002	336929	567	8420	23093	178912	125937
2003	515438	613	12776	29938	236176	235935
